

АГУУЛГА

ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3
БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1. Төслийн байршил	4
1.2. Орчны төлөв байдал.....	5
1.3. Ордын геологийн нөөц	6
1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц	6
1.5. Уурхайн хүчин чадал, ажиллах горим	6
1.6. Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал	7
1.7. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл	8
1.8. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл	8
БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД.....	9
2.1. Агаарын чанарт нөлөөлөх байдал	9
2.2. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал.....	9
2.3. Усны чанарт нөлөөлөх байдал.....	9
2.4. Хөрсний чанарт нөлөөлөх байдал.....	9
2.5. Ургамалан нөмрөгт нөлөөлөх байдал	9
2.6. Амьтны аймагт нөлөөлөх байдал.....	10
2.7. Төсөл хэрэгжих орчны түүх соёлын дурсгалт зүйлс.....	10
2.8. Төслийн болзошгүй сөрөг нөлөөллүүд	10
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН.....	12
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	14
3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	16
3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	18
3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	18
3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	18
3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	23
3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	25
3.9. Аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	28
3.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	29
3.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	30
3.12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нэгтгэл.....	31
ДҮГНЭЛТ	32
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол	4
Хүснэгт 1.2. “Зуун мод-2” барилгын элсний ордын батлагдсан геологийн нөөц	6
Хүснэгт 1.3. Уурхайн ажиллах горим.....	7
Хүснэгт 1.4. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд	8
Хүснэгт 1.5. Элс шигших үндсэн тоног төхөөрөмжүүд	8
Хүснэгт 2.1. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь.....	10
Хүснэгт 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
Хүснэгт 3.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт	16
Хүснэгт 3.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	21
Хүснэгт 3.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	24
Хүснэгт 3.5. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	29
Хүснэгт 3.6. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь	30
Хүснэгт 3.7. 2023 оны БОМТ-ний нийт зардал, биелэлтийн үзүүлэлтүүд	31

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Төслийн талбайн байршлын зураг	4
Зураг 1.2. Элс шигших чичиргээт шигшүүр	8
Зураг 3.1. Ажилчдын байрны орчмыг цэцэрлэгжүүлсэн байдал.....	13
Зураг 3.2. Шавьж устгал, ариутгал хийж буй байдал	14
Зураг 3.3. Уурхайн ашиглагдсан талбайд нөхөн сэргээлт хийж буй байдал.....	14
Зураг 3.4. Уурхайн талбайд нэмж мод тарьсан байдал	15
Зураг 3.5. Уурхайн талбайд тарьсан моднуудын ургалтын байдал.....	15
Зураг 3.6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардлын баримт	16
Зураг 3.7. Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр мод тарьсан ажлын тайлан	17
Зураг 3.8. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүд	18
Зураг 3.9. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангасан байдал	19
Зураг 3.10. Аюулгүй ажиллагааны самбарыг шинэчилсэн байдал.....	19
Зураг 3.11. Уурхайн зам талбайг тэмдэгжүүлсэн байдал	19
Зураг 3.12. Уурхайн замыг хаалт хийн тэмдэгжүүлсэн байдал.....	20
Зураг 3.13. Гал унтраах багаж хэрэгслүүдийг шинэчилж буй байдал	20
Зураг 3.14. Гал унтраах багаж хэрэгслүүд	21
Зураг 3.15. Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ, төлбөрийн хэмжээ	23
Зураг 3.16. Бохир ус татан зайлуулах гэрээ, төлбөрийн баримт	24
Зураг 3.17. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил.....	25
Зураг 3.18. Хөрсний шинжилгээний хариу	26
Зураг 3.19. Усны шинжилгээний хариу.....	27
Зураг 3.20. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажил	28
Зураг 3.21. Нийгмийн хариуцлагын гэрээ, 2022-2023 он.....	29

ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

№	ҮЗҮҮЛЭЛТ	УТГА
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“СЭРҮҮН СЭЛБЭ” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн улсын бүртгэлийн мэдээлэл	Улсын бүртгэлийн дугаар: 9011018149 Бүртгэсэн огноо: 2006.10.02 Регистрийн дугаар: 2851768
3	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, ДЦС-3-ын баруун талд, Өөрийн байр
4	Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын мэдээлэл	Захирал: С.Сарангэрэл Утас: 9999-7959
5	Төслийн нэр	Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зуун мод-2” барилгын элсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл
6	Төслийн байршил	Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 5-р хороо
7	Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-013322, MV-013323
8	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Олгосон огноо: 2008.03.03 Дуусах огноо: 2037.02.03
9	Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ	MV-013322 - 40.3 га MV-013323 - 13.8 га
10	Ордын барилгын элсний батлагдсан геологийн нөөц	1468.51 мян.м ³ (2022 оны ТЭЗҮ)
11	Ордын барилгын элсний үйлдвэрлэлийн нөөц	1437.32 мян.м ³ (2022 оны ТЭЗҮ)
12	Элс олборлолтын жилийн хүчин чадал	80.0 мян.м ³

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


1.1. Төслийн байршил

“Зуун мод-2” барилгын элсний уурхай нь засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотын Налайх дүүргийн 5-р хорооны нутагт хамаарах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс зүүн тийш 52 км зайд, Монгол улсын 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн L-48-11 тоот хавтгайд оршино.

Уг уурхай орших нийт 54.1 га талбай бүхий MV-013322, MV-013323 тоот түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайн булангийн цэгүүдийн солбилцолыг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1.1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол

№	Тусгай зөвшөөрлийн дугаар, талбайн нэр	Талбайн хэмжээ, га	Солбилцол	
			Өргөрөг	Уртраг
1	MV-013322 Зуун модны элс-1	40.30	47° 47' 10.73"	107° 29' 26.37"
2			47° 47' 10.73"	107° 28' 36.37"
3			47° 47' 16.77"	107° 28' 36.37"
4			47° 47' 29.76"	107° 29' 26.37"
5	MV-013323 Зуун модны элс-2	13.82	47° 47' 30.46"	107° 29' 26.37"
6			47° 47' 17.47"	107° 28' 36.37"
7			47° 47' 21.77"	107° 28' 36.37"
8			47° 47' 34.76"	107° 29' 26.37"



Зураг 1.1. Төслийн талбайн байршилын зураг

1.2. ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Газрын гадаргуугийн байдал: Төслийн талбай нь Монгол орны физик газар зүйн мужлалаар Хэнтийн уулсын баруун урд хэсэгт уртаараа 20 км, өргөнөөрөө 10 км хүрэх Налайхын хотгорт хамаарагдана. Уул зүйн хэлбэршлийн хувьд далайн түвшнээс дээш 1400-1550 м өргөгдсөн хотгор гүдгэр хэв шинжтэй, намхан бэсрэг уулсын толгодорхог гадаргуутай юм. Төслийн талбайн хувьд зүүн урдаас баруун хойш сунасан, зүүнээс баруун тийш бага зэрэг налуу, ордын төв хэсгээр тэгшивтэр гадаргуутай, хамгийн өндөр цэг нь 1440.0 м бол нам цэг нь 1420.0 м өндөржилттэй байна.

Цаг агаар: Манай орны бүх нутаг дэвсгэрийн адил эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай, хүйтэн өвөлтэй хуурай эх газарлаг мужид хамаарагддаг. Жилийн дундаж агаарын температур -23.7 хэмээс +21.8 хэм ба хамгийн хүйтэн болох 01-р сард агаарын температур нь -31 хэмээс -35 хэм хүртэл хүйтэрч, хамгийн дулаан үе нь 07-р сард +25 хэмээс +35 хэм хүртэл халуун болдог. Жилийн аль ч улиралд баруун, баруун хойноосоо зүүн урагшаа чиглэлтэй салхилдаг.

Хөрс ургамал: Төслийн талбай орчимд хар хүрэн, хүрэн бор сэвсгэр хурдас зонхилон тархах ба тал хээрийн бүсэд ургадаг хялганат хазаар, шивээ зэрэг бэлчээрийн ач холбогдолтой ургамлаар баян нутаг юм. Хааяа уулс, цав толгод тал газрын дагуу дорнод монголын хэв шинж бүхий алаг хялганат хиаг өвс, элсэг алаг өвс ба сөөгөн ширэнгэт, чулуусаг алаг хялганат өвс, тал хээрийн хэв шинж бүхий харгана, үетэн хиаг, хялганат хиаг зэрэг ургамлуудтай.

Ус зүй: Дүүргийн хэмжээнд гадаргуугийн усан сүлжээ сайн хөгжсөн ба байнгын урсгал устай Туул гол талбайгаас хойш 5 км зайтай урсах ба талбайн эргэн тойрон ширгэж татарсан булаг шанд хэд хэд тэмдэглэгдсэн байдаг. Түүнчлэн цөөн тооны хуурай сайрууд тохиолдох ба эдгээр нь нэлээд хэдэн зуун метр үргэлжлэх бөгөөд ширүүн бороотой үед түр зуурын урсгал ус бий болдог. Усны эх үүсвэр нь хоорондоо харилцан адилгүй зайтай хэдэн гүний худгууд бөгөөд усны нөөц ерөнхийдөө тогтворгүй.

Зам харилцаа, дэд бүтэц: Төслийн талбай нь зам харилцаа сайн хөгжсөн ба Улаанбаатар хотоос зүүн тийш 60 км, Налайх дүүргээс зүүн тийш 20 км зайд байрлана. Төмөр замын зангилаа болох Налайх өртөө ордоос баруун тийш 20 км, хатуу хучилттай автозам болон өндөр хүчдэлийн шугам хойд зүгт 0.5 км зайтай байна. Монгол орны босоо, хэвтээ тэнхлэгийг холбосон хатуу хучилттай замын уулзвар газар, мөн ойр орчимд элсний олон тооны ордууд ашиглагдаж байгаа нь дэд бүтэц, зам харилцаа маш сайтай гэдгийг харуулж байна.

Хүн ам зүй: Манай орны төвийн бүсийн дэд бүтэц сайн хөгжсөн нутаг дэвсгэрт хамрагдах ба талбайн ойр орших Налайх дүүрэгт засаг захиргааны байгууллага, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, шуудан холбоо, үүрэн телефоны сүлжээ зэрэг орчин үеийн бүхий л хэрэглээний технологиуд нэвтэрсэн байна. Уг дүүрэгт хүн ам харьцангуй нягт суурьшилтай бөгөөд дийлэнх хэсэг нь дээрх байгууламжууд болон хувийн бизнес арилжаа эрхлэхийн зэрэгцээ нүүрсний уурхай, элс, дайрга, шаврын орд газруудыг олборлох, тоосго үйлдвэрлэх зэрэг ажил эрхэлдэг.

1.3. Ордын геологийн нөөц

Геологийн тогтоцын шинж чанар, ашигт малтмалын нөөцийн хэмжээгээр “Зуун мод-2” элсний орд нь “Элс-хайрганы ордод нөөцийн ангилал хэрэглэх заавар”-ын дагуу II бүлгийн ордод хамаарахыг ордын нөөцийн тайланг зохиогчид тодорхойлжээ.

Уг ордод 2009 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд ордын талбайн хэмжээнд бодитой (B) зэрэглэлийн нөөц бүхий 4 блок ялган ордын элсний нийт нөөцийг 1561.1 мян.м³-ээр тогтоон ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

Хүснэгт 1.2. “Зуун мод-2” барилгын элсний ордын батлагдсан геологийн нөөц

№	Нөөцийн блокийн дугаар, нөөцийн зэрэглэл	Блокийн талбай, кв.м	Хөрсний дундаж зузаан, м	Ашигт малтмалын дундаж зузаан, м	Хуулах хөрсний эзэлхүүн, м ³	Ашигт малтмалын нөөц, м ³	Хөрс ба ашигт малтмалын харьцаа
1	B-I	62946	0.23	2.74	14477.6	163228.8	1:11
2	B-II	74596	0.22	2.85	16411.2	212598.6	1:12
3	B-III	199329	0.2	2.9	39865.8	536000.5	1:13
4	B-IV	204172	0.22	3.18	44917.9	649266.9	1:14
Нийт: Бодитой (B) нөөц		541043	0.87	11.67	115673	1 561 095	1:12

1.4. Ордын үйлдвэрлэлийн нөөц

“Сэрүүн сэлбэ” ХХК нь “Зуун мод-2” элсний уурхайгаас 2022 оныг хүртэл нийт 92.79 мян.м³ элс олборлосон байгаа ба уг нөөцийг анх батлагдсан геологийн нөөцөөс хассаны дараах үлдэгдэл геологийн нөөц болох 1468.51 мян.м³ нөөц дээр уг ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг 2022 онд боловсруулж батлуулжээ.

Дээрх үлдэгдэл геологийн нөөцийг ил уурхайн аргаар ашиглах үеийн үйлдвэрлэлийн нөөц нь 1437.32 мян.м³ байхаар 2022 оны ТЭЗҮ-д тооцож тусгасан байна.

1.5. Уурхайн хүчин чадал, ажиллах горим

Уурхайн хүчин чадал: Уурхайн хүчин чадлыг техник-эдийн засгийн үндэслэлд жилд 80.0 мян.м³ барилгын элс олборлохоор тооцож тусгасан байна.

Уурхайн ажиллах горим: “Зуун мод-2” элсний уурхай нь улирлын чанартай ажиллах бөгөөд 4-р сарын 15-наас 10-р сарын 15-ныг хүртэл жилд нийтдээ 6 сар ажиллана.

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулах горимын үзүүлэлтүүдийг уурхайн ажиллах хугацаа болон Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн тооцоолж дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 1.3. Уурхайн ажиллах горим

№	Горимын үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
1	Жилийн хуанлийн хоног	хоног	365	-
2	Өвлийн улирлын сул зогсолт	хоног	181	10-р сарын 15-аас 04-р сарын 15 хүртэл
3	Уурхайн ажиллах хоног	хоног	184	04-р сарын 15-аас 10-р сарын 15 хүртэл
4	Баяр ёслолын амралт	хоног	5	Хөдөлмөрийн тухай хуулийн 97.1.4, 97.1.5, 97.1.6-р зүйлийн дагуу
5	Цаг агаарын саатал	хоног	10	-
6	Засвар үйлчилгээ	хоног	10	Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус
7	Жилд ажиллах бодит хоног	хоног	159	-
8	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	1	-
9	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	8	Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу
10	Цаг ашиглалтын коэффициент	-	0.9	90%
11	Нэг ээлжин дэх цэвэр ажлын цаг	цаг	7.2	Цаг ашиглалт тооцсон
12	Хоногт ажиллах бодит цаг	цаг	7.2	Цаг ашиглалт тооцсон
13	Жилд ажиллах бодит цаг	цаг	1030	Цаг ашиглалт тооцсон
14	Уурхайн цагийн хүчин чадал	м ³ /цаг	69.88	Цаг ашиглалт тооцсон
15	Уурхайн ээлжийн хүчин чадал	м ³ /ээлж	503.14	Хоногт 8 цагийн 1 ээлжээр ажиллана
16	Уурхайн хоногийн хүчин чадал	м ³ /хоног	503.14	
17	Уурхайн жилийн хүчин чадал	м ³ /жил	80000.00	Жилд нийтдээ 159 хоног ажиллана

Уурхайн ажиллах горимд үндэслэн тооцоход хоногийн хүчин чадал 503.14 м³, цагийн хүчин чадал 69.88 м³ байхаар байна.

1.6. УУРХАЙН ТАЛБАЙД АШИГЛАЛТ ЯВУУЛАХ ДАРААЛАЛ

“Зуун мод-2” барилгын элсний ордод ашиглалт явуулах үйл ажиллагаа нь дараах технологийн дагуу явагдана.

Элс олборлолт: ШИМТ ХӨРС ХУУЛАЛТ ► ХӨРС ХУУЛАЛТ ► ЭЛС ОЛБОРЛОЛТ ► ЭЛС ШИГШИЛТ ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД НИЙЛҮҮЛЭХ.

Үүний зэрэгцээ уурхайн тээврийн замыг цэвэрлэх, хуурайшилт ихтэй үед тоосжилтыг бууруулах мөн тоног төхөөрөмжид засвар, үзлэг үйлчилгээ хийх гэх мэт туслах ажлууд хийгдэнэ.

1.7. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

Уурхайд олборлолтын үйл ажиллагаа явуулахаас өмнө үржил шимт хөрсний үеийг бульдозероор хусаж бөөгнүүлэн автосамосвалд ачиж тээвэрлэн тусгай овоолгод байршуулж стандартын дагуу хадгална.

Тухайн жилийн ашиглалтанд өртөх талбайн шимт хөрс болон хөрсийг хуулсны дараа нээгдсэн элсний үеийг экскаватораар сийрэгжүүлэн ухаж автосамосвалд ачин цааш үйлдвэрийн талбай руу тээвэрлэж элс шигшин ангилах төхөөрөмжийн хүлээн авах туузан дамжуулагчид хүргэнэ.

Хүснэгт 1.4. Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд

№	Техник	Марк	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Экскаватор (уулын цул)	Hyundai	1	1.5 м ³
2	Автосамосвал (уулын цул)	HOWO	2	40 тн
3	Бульдозер	Shantui SD16	1	131 кВт
4	Утгуурт ачигч	Luigong ZL50B	1	1.5 м ³
-	Нийт	-	3	-


1.8. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

Элс шигшин баяжуулах үйл ажиллагаа нь түүхий эд, материалыг бутлан шигшихэд бэлдэх, шигших, эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх гэсэн ерөнхий шат дараалалтай явагдана.

Элс шигшин баяжуулах үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмжүүдийг Налайх орчимд үйл ажиллагаа явуулж буй ижил төстэй үйлдвэрүүдийн жишиг байдлаар сонгон авсан болно.

Хүснэгт 1.5. Элс шигших үндсэн тоног төхөөрөмжүүд

№	Тоног төхөөрөмжүүд	Марк	Хүчин чадал	Тоо
1	Утгуурт ачигч	ZL50B	1.5 м ³	1
2	Шигшүүр	ГИЛ-43	200 тн/цаг	1
3	Туузан дамжуулагч	DS50x8	1.3 м/сек	3



Зураг 1.2. Элс шигших чичиргээт шигшүүр

БҮЛЭГ-2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

2.1. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ БАЙДАЛ

Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос, шороо болон агаарын хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.

Элс олборлох уурхайд

- Хөрс хуулах, элс олборлох үед тоос үүсэх
- Тээврийн хэрэгсэл явах үед боссон автозамын тоос
- Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий
- Уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос
- Хөрс болон элсийг тээвэрлэх үед үүсэх тоос, шороо нь агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болдог.

Үүнээс уурхайн малталтууд болон овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаар орчныг байнга бохирдуулдаг бөгөөд салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшил зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд нөлөөллийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

2.2. Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал

Элс олборлох ажлын байгаль орчинд үзүүлэх экологийн гол үр дагавар нь газрын хурдсыг эвдэж, нүх, карьер үүсэх, улмаар агаарын тоосны бохирдол ихсэх, энэ нь ойр орчимдоо тархах, байгаль хамгаалах шаардлагатай арга хэмжээ авч сөрөг нөлөөллийг бууруулахгүй бол цөлжилт явагдах, цаашид хүрээгээ тэлэхэд хүргэж болзошгүй.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй шатах тослох материалын хадгалалт, ашиглалтанд байнгын хяналт тавьж болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх шаардлагатай болно.

2.3. Усны чанарт нөлөөлөх байдал

Уурхайн орчим урсгал ус байхгүй бөгөөд геологи хайгуулын үед шаврын олборлолтын давхаргад гүний ус илрээгүй нилээд гүнд байгаа учир энэ төрлийн нөлөөлөл бага юм.

2.4. Хөрсний чанарт нөлөөлөх байдал

Хүнд машин механизмын хөдөлгөөнөөс хөрс эвдрэх, элэгдэлд орох зэргээр хөрс, ургамлын хүний үйл ажиллагаанд өртөж буй талбайн хязгаар нь түүнээс нилээд хол зайд, наад зах нь 500-1000 м болж, нөлөөллийн хүрээ нь тэлж болохыг цаашид анхаарах шаардлагатай юм.

2.5. Ургамалан нөмрөгт нөлөөлөх байдал

Төсөл хэрэгжих явцад тухайн орд ашиглах газрын ургамлын бүрхэвч агаар, хөрсний бохирдлоос үүдэн ихээхэн хэмжээний доройтолд орсон нь ажиглагдаж байсан.

2.6. Амьтны аймагт нөлөөлөх байдал

Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймгийн төлөөлөгчдийн идэш тэжээлийн хэлхээ холбоо тасрах, амьдрах нутгийн хүрээ хумигдах, нүүдэллэх талбай хаагдах, техникийн дуу чимээ, доргио чичиргээ, бензин тосны үнэр зэргээс тайван байдал нь алдагдаж, амьдрах орчноосоо дайжих байдлаар тухайн экосистем тодорхой хэмжээгээр өөрчлөгдөнө.

Сээр нуруугүй амьтад, ялангуяа шавж, аалз хэлбэртэн байгалийн аливаа нэг биоценозод тохиолдох нийт амьтдын биомассын ихэнх буюу 90 хүртэл хувийг бүрдүүлэх бөгөөд тухайн орчинд явагдаж байгаа бодис, энергийн эргэлт, хувирлыг хэвийн явуулах, түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Ийм учраас хөрсний амьтдын зонхилох хэсгийн зүйл, тэдгээрийн тоо толгойн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсноор тухайн экосистемийн тогтолцоонд өөрчлөлт хувьсал гарах нь дамжиггүй.

Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, хатуу хог хаягдлыг ил задгай хаях, эвдэрсэн газрыг хөрсжүүлэх ажил орхигдоход хөрсөнд амьдрагч сээр нуруугүйтэн, жижиг мэрэгчид, тэдгээрээр хооллогч хөхтөн, шувуудын тоо толгой цөөрөх үйл явц ажиглагдана. Энэ нь амьтан, ургамлын аймгийн төлөөлөгчид харилцан шүтэлцээтэйгээр экосистемийг бүрэлдүүлэх биологийн зүй тогтол юм.

2.7. Төсөл хэрэгжих орчны түүх соёлын дурсгалт зүйлс

Уг элсний ордын талбай нь байгалийн цогцолборт газарт хамаарахгүй бөгөөд түүх, соёлын дурсгалт зүйл талбайн хэмжээнд байхгүй. Хэрэв олборлолтын явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл дүүргийн болон нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагуудад хандах хэрэгтэй.

2.8. Төслийн болзошгүй сөрөг нөлөөллүүд

Хүснэгт 2.1. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	X			X			X		X	
Ургамлын бүтцийн өөрчлөлт	X			X			X		X	
Хөрсний элэгдэл, эвдрэл	X				X		X		X	
Геологийн тогтоцын өөрчлөлт	X				X		X		X	
Зэрлэг амьтдын орон зай		X		X			X			X
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										X

2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										X
Бэлчээрийн байдал	X	X			X		X		X	
Эрдэс түүхий эдийн нөөц	X				X		X	X		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ										X
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	X			X			X		X	
Хөрсний эвдрэл, бохирдол	X				X		X		X	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		X								X
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	X			X			X		X	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	X				X		X		X	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	X				X		X		X	
Орон нутгийн орлого нэмэгдэх	X				X		X		X	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	X				X		X			X
Ажлын байр нэмэгдэх	X				X	X			X	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	X				X	X			X	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		X		X			X			X
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	X			X	X	X			X	
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс, ба грунтын усыг бохирдуулах	X						X			X
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	X			X		X				X
Хүчтэй салхи, уруйн үер	X			X			X			X
Дүн	18	3	0	10	11	4	17	2	13	6

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

3.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлсэн ба холбогдох тайлбар, үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хэрэгжүүлэгч	Зардал, мян.төг	Гарсан үр дүн
Хөрсөн бүрхэвч					
1	Ажилчдад шатах, тослох материалтай хэрхэн харьцах, түүнээс үүсэх эрсдэлээс хэрхэн сэргийлж, ямар арга хэмжээ авах талаар сургалт зохион байгуулсан	Жилд 1 удаа	“Сэрүүн сэлбэ” ХХК	250.0	Шатах тослох материалын асгаралтаас сэргийлсэн
2	Тээврийн хэрэгслийг маршрутын бус замаар явахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг сайжруулсан	Төслийн үйл ажиллагааны явцад	“Сэрүүн сэлбэ” ХХК	250.0	Хөрс элэгдэл эвдрэлд орох, тоосжилтоос сэргийлсэн
3	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах, асгарч алдагдахаас сэргийлэх, хөрс, гүний ус бохирдохоос сэргийлэх, бохирдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авч ажилласан.	Байнга	Байгаль орчны мэргэжилтэн	140.0	Хөрс бохирдохоос сэргийлсэн
4	Ажилчдын байрны ойр орчмыг цэцэрлэгжүүлсэн	Төслийн явцад	“Сэрүүн сэлбэ” ХХК	500.0	Тоос босохоос сэргийлсэн
5	Хортон шавьжийн устгалыг тогтмол хийлгэж ажилласан.	Жилд 2 удаа	“Сэрүүн сэлбэ” ХХК	360.0	Хөрс бохирдохоос сэргийлсэн
Агаарын орчин					
1	Элсний олборлолтын үед тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, салхи ихтэй үед тоос багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн	Байнга	“Сэрүүн сэлбэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Тоосжилтоос сэргийлсэн
2	Тоос шороотой нөхцөлд ажиллаж байгаа ажилчдыг тоосжилтоос хамгаалах зорилгоор өдөрт нормын сүү, цагаан идээ өгсөн	Байнга	“Сэрүүн сэлбэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Ажилчдын эрүүл мэндэд анхаарсан
3	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны	Төслийн үйл ажиллагааны явцад	“Сэрүүн сэлбэ” ХХК	500.0	Агаарын бохирдлоос сэргийлсэн

	хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авч ажилласан				
Усан орчин					
1	Үер усны аюулаас сэргийлэхийн тулд хамгаалалтын далан байгуулсан	Төслийн үйл ажиллганы явцад	“Сэрүүн сэлбэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр	Үер усны аюулаас сэргийлсэн
Нийт дүн			2000.0		

Ажилчдын байрны орчмыг цэцэрлэгжүүлж ажилчдын амрах, ая тухтай байх нөхцлийг сайжруулж ажиллав.



Зураг 3.1. Ажилчдын байрны орчмыг цэцэрлэгжүүлсэн байдал



Зураг 3.2. Шавьж устгал, ариутгал хийж буй байдал

3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

2023 онд уурхайн олборлолт явуулсан хэсэгт 0.2 га газарт техникийн нөхөн сэргээлт хийлээ. Мөн уурхайн талбайд өмнөх жилүүдэд тарьж ургуулсан моднуудад нэмж мод тарих, тарьсан моднуудаа арчлах байдлаар биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэлээ.

2023 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажилд нийтдээ 2.5 сая төгрөг зарцууллаа.



Зураг 3.3. Уурхайн ашиглагдсан талбайд нөхөн сэргээлт хийж буй байдал



Зураг 3.4. Уурхайн талбайд нэмж мод тарьсан байдал



Зураг 3.5. Уурхайн талбайд тарьсан моднуудын ургалтын байдал


3.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2023 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд НБОГ-с санал болгосон Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэр дэх Бага хуандийн аманд нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд оролцохоор төлөвлөсөн.

Хүснэгт 3.2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг
	1	2	3	4	5	6
1.	Дүйцүүлэн хамгаалалт	НБОГ-с санал болгосон газарт	Нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд оролцоно	1	2'000'000.0	2'000'000.0
-	Нийт	-	-	-	-	2'000'000.0

Энэхүү нэгдсэн зохион байгуулалтаар мод тарих ажилд 2.0 сая төгрөг шилжүүлэн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг биелүүлсэн.




Сайн сайхныг саналархуулалт

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн заавлах дугаар: 218382473 Тарсан огноо: 2023-11-07 12:18

Шилжүүлэгчийн давсны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
1809153847 MN610015001809153847	1102733850	2,000,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр САРАНГЭРЭЛ САЙНЦОГ	Хүлээн авагчийн нэр НУРИ ХХК	Гүйлгээний утга сэрүүн сэлбэ нөхөн сэргээлт дүйцүүлэх төлбөр	
	Хүлээн авагчийн банк Голомт Банк	Гүйлгээний огноо 2023-11-03	



Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

Зураг 3.6. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардлын баримт



Зураг 3.7. Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр мод тарьсан ажлын тайлан

3.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно.

3.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй ба 2023 оны ашиглалтын явцад түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй болно.

3.6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ажилчдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын дагуу ажилчдад хамгаалах хэрэгсэл, нүдний шил, хамар амны маск, чихний бөглөө, хатуу малгай, бээлий, тохиромжтой гутал зэрэг ХАБЭА-н хэрэгслээр бүрэн хангаж, байнга өмсүүлж, хэрэглүүлж хэвшүүлсэн. Төслийн үйл ажиллагаа эхэлсэнээс хойш ямар нэгэн осол аваар гараагүй болно.



Зураг 3.8. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслүүд



Зураг 3.9. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангасан байдал



Зураг 3.10. Аюулгүй ажиллагааны самбарыг шинэчилсэн байдал



Зураг 3.11. Уурхайн зам талбайг тэмдэгжүүлсэн байдал



Зураг 3.12. Уурхайн замыг хаалт хийн тэмдэгжүүлсэн байдал



Зураг 3.13. Гал унтраах багаж хэрэгслүүдийг шинэчилж буй байдал



Зураг 3.14. Гал унтраах багаж хэрэгслүүд

Бид ажилчдынхаа эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж гэнэтийн болон болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахаар хичээж ажиллаж байгаа ба манай төслийн үйл ажиллагаа эхэлсэн үеэс эхлэн ямар нэгэн осол аваар гараагүй болно.

Хүснэгт 3.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Зардал, мян.төг	Хэрэгжүүлсэн хугацаа
1	Автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулсан	750.0	Төслийн үйл ажиллагааны явцад
		Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад байрлуулсан	300.0	Уурхай эхлэх үед
3	Хүчтэй аадар бороо, аянга цахилгааны улмаас ажлын байрны аюулгүй байдал, цахилгаан тасрах, хүний амь нас, эрүүл мэнд хохирох	Аянга, цахилгаантай ширүүн бороотой үед үйлдвэрийн ажлыг түр зогсоож байсан	-	Төслийн хугацаанд
4	Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, элс олборлолт болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа	Ажилчдыг ажилдаа гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажилласан	-	Өдөр бүр

	саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан	200.0	Жилд 1 удаа
5	Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс тээврийн хэрэгслүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж, бэртээх гэх мэт осол аваар гарах	-Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан, -Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулсан	500.0	Жил бүр
Нийт			1'750.0	

3.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгахын тулд Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын дарга Ц.Эрболтой 2023 оны 04-р сарын 18-ны өдөр хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээг 1 жилийн хугацаатай байгуулан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж хадгалан тээвэрлүүлэх ажлыг гүйцэтгүүлж байна.

Энэхүү гэрээгээр Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам”, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн ИТХ-ын 2012 оны 61-р тогтоол, Дүүргийн засаг даргын 2013 оны 04-р сарын 26-ны өдрийн 165-р захирамжийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байгаа болно.

Дээрх гэрээний дагуу сар бүр 99'000.0 төгрөг, нийт 5 сарын хугацаанд 495'000.0 төгрөгийг Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын ХААН банкны 5749062084 тоот дансанд тушаасан болно.



Зураг 3.15. Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ, төлбөрийн хэмжээ



Зураг 3.16. Бохир ус татан зайлуулах гэрээ, төлбөрийн баримт


“Чандмань Налайх” ОНӨААТҮГ-тай Бохир ус татан зайлуулах гэрээ байгуулж, гэрээний төлбөрт нийтдээ 57.42 мянган төгрөг төлж холбогдох ажлыг гүйцэтгүүлэв.

Хүснэгт 3.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Зардал, мян.төг
1	Төвлөрсөн цэгт хогийг тухай бүрт тээвэрлүүлэх ажлыг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлэв	“Сэрүүн сэлбэ” ХХК	495.0
2	Бохир ус татан зайлуулах ажлыг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлэв		55.0
Нийт дүн		550.0	

3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрс, усны шинжилгээ, агаар, дуу чимээний хэмжилтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэлээ. Энэ ажилд нийтдээ 250.0 мянган төгрөг зарцуулсан болно.



Зураг 3.17. Хөрсний дээж авсан цэгүүдийн байршил



“НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/10-20/1

Захиалагч: “Сэрүүн сэлбэ” ХХК
Дээж авсан цэг: “Сэрүүн сэлбэ” ХХК, НД 5-р хороо
Сорьц авсан огноо: 2023 оны 10 сар 13 өдөр
Шинжилгээ хийсэн огноо: 10 сарын 20

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан үе давхарга	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO ₃ , %	NO ₃ , мг/100г	Солидох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca ²⁺	Mg ²⁺	P ₂ O ₅	K ₂ O
Дээж 1, 47 47 23.9, 107 28 52.6											
1	0-45	7.47	0.022	0.052	1.35	0.0	0.13	11	5	3.8	4
Дээж 2, 47 47 20.2, 107 28 48.3											
2	0-10	7.48	0.028	0.066	0.54	0.0	0.09	4	6	4.4	6
Дээж 3, 47 47 18.32, 107 28 53.0											
3	0-25	7.43	0.029	0.067	0.66	0.0	0.11	8	2	3.8	8
Дээж 4, 47 47 21.3, 107 28 48.3											
4	0-10	7.36	0.034	0.08	0.88	0.0	0.32	13	4	3.4	10
Дээж 5, 47 47 28.8, 107 29 13.6											
5	0-30	7.43	0.028	0.066	0.61	0.0	0.12	8	2	4.2	4

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан үе давхарга	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1, 47 47 23.9, 107 28 52.6								
1	0-45	63.9	24.9	4.0	1.0	3.4	2.9	7.2
Дээж 2, 47 47 20.2, 107 28 48.3								
2	0-10	59.5	30.7	2.5	3.3	2.7	1.3	7.3
Дээж 3, 47 47 18.32, 107 28 53.0								
3	0-25	73.2	17.1	2.6	3.5	3.2	0.4	7.2
Дээж 4, 47 47 21.3, 107 28 48.3								
4	0-10	37.5	35.5	3.6	8.9	3.5	10.9	23.3
Дээж 5, 47 47 28.8, 107 29 13.6								
5	0-30	67.1	19.3	1.7	8.4	2.2	1.3	11.9

3. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан үе давхарга	Cr, мг/кг	Pb, мг/кг	Cd, мг/кг	Zn, мг/кг	Cu, мг/кг	Ni, мг/кг
Дээж 1	0-45	0.0	7.2	0.0	45.4	12.2	2.6
Дээж 4	0-10	0.0	21.5	0.0	83.7	25.0	13.8
Дээж 6	Өнгөн	0.0	17.9	0.0	40.0	11.0	1.7
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хорс		60	50	1	100	60	60
Шаврангар хорс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хорс		150	100	3	300	100	150

*Харгалзах түвшин * Жич: Эгэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжтэй хамаарна

ЗАДЛАН ШИНЖЛИГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД: (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Хүнд металлуудыг - хаан дарсанд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖЛИГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУГАНЦЭЦЭГ, Д.ЭНХЧИМЭГ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

Зураг 3.18. Хөрсний шинжилгээний хариу



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ - ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УСНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2023 оны 07 сарын 31 өдөр
Шинжилгээ хийсэн: 2023 оны 08 сарын 02 өдөр
Сорьц авсан газрын нэр: Налайх дүүрэг, Элстэйн гол
"Сэрүүн Сэлбэ" ХХК, 2-р худаг,
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Гидропараметр" ХХК

Солбицлол X=47°47'18.25" Гүн: 30 м 2023 он
Y=107°28'42.16" Ундарга: 3.0 л/с
Уст цэгийн төрөл ба дугаар: худаг Н=1422 м

Тодорхойлсон нь:

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг	мг-экв	мг-экв%		мг	мг-экв	мг-экв%
Cl ⁻	9.2	0.26	7.6	Na ⁺ +K ⁺	28.5	1.24	36.1
SO ₄ ²⁻	15.0	0.31	9.1	Ca ²⁺	35.5	1.77	51.6
NO ₂ ⁻	0.0	0.00	0.0	Mg ²⁺	5.1	0.42	12.2
NO ₃ ⁻	16.0	0.26	7.5	NH ₄ ⁺	0.0	0.00	0.0
CO ₃ ²⁻	0.0	0.00	0.0	Fe ²⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	158.6	2.60	75.8	Fe ³⁺	0.05	0.00	0.1
Дүн	198.8	3.43	100.0	Дүн	69.1	3.43	100.0

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын
нийлбэр: 188.6 мг/дм³

Анион катионуудын
нийлбэр: 267.9 мг/дм³

Ерөнхий хатуулаг: 2.19 мг-экв/дм³
рН: 7.14

ЕС: 296 µS/cm
TDS: 178 ppm

Исэлдэх чанар: 1.60 мг/дм³

Физик шинж чанар

Тунгалаг: 30 см
Өнгө: үгүй

Үнэр: үгүй
Амт: ***

Тунадас: үгүй
Булингар: 1.3 NTU

HCO₃ 76

Усны найрлагын томъёо: M_{0.27} Ca²⁺52 Na⁺+K⁺36 Mg²⁺12

Дүгнэлт

Хийгдсэн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөн ус байна. Шинжилсэн хийгдсэн үндсэн үзүүлэлтүүд нь "Ундны усны стандарт MNS 900:2018" стандартын шаардлага хангаж байна.

Жич: Энэхүү уст цэвээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцаан гүйцэтгэсэн болно.

Гүйцэтгэсэн: Химич, ЭШДэА  Г.Зэнхаргал/
Шинжилгээг Хянаж, баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч,  /Д. Гэрэлт-Од/

Зураг 3.19. Усны шинжилгээний харуу

3.9. Аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ



Манай компани Налайх дүүрэгтэйгээ жил бүр “Нийгмийн хариуцлагын гэрээ”-г шинэчлэн байгуулж хамтран ажилладаг болно.

Налайх дүүргийн хүсэлтийн дагуу 2023 оны зуны үерийн гамшигийн үед тус дүүргийн 8-р хорооны үерийн далангийн ажилд 4'320.0 мянган төгрөгийн үнэ бүхий хайрга нийлүүлж дэмжлэг үзүүлсэн болно.



Зураг 3.20. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажил

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГТ ОРШИХ “ЗУУН МОД-2” БАРИЛГЫН ЭЛСНИЙ УУРХАЙН
2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 3.21. Нийгмийн хариуцлагын гэрээ, 2022-2023 он

3.10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн жилийн буюу 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажилласан ба холбогдох тайлбар, үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 3.5. Удирдлага зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа, давтамж	Хэрэгжүүлэгч	Зардал, мян.төг
1	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж, зөвлөгөө авч ажилласан	2023 онд	“Сэрүүн сэлбэ” ХХК	1000.0
2	Элсний орд, үйлдвэрийн ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн талаар сургалт, семинарыг тогтмол зохион байгуулсан	Жил бүр	“Сэрүүн сэлбэ” ХХК	250.0
3	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулсан	Төслийн үйл ажиллагааны явцад	“Сэрүүн сэлбэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
4	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан	Жилд 1 удаа	“Сэрүүн сэлбэ” ХХК	250.0
5	Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийн гадаад орчныг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар арга хэмжээ зохион байгуулсан	Жил бүр	“Сэрүүн сэлбэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр

6	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байсан	Төслийн хугацаанд	“Сэрүүн сэлбэ” ХХК	Дотоод төлөвлөлтөөр
Нийт дүн				1500.0

“Сэрүүн сэлбэ” ХХК нь Налайх дүүргийн 20 гаруй иргэдийг ажлын байраар ханган үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид цаашдын үйл ажиллагааныхаа явцад ажиллах хүчнийхээ эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлж байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөлөл багатайгаар үйл ажиллагаагаа явуулах бүх шатны арга хэмжээгээ сайжруулан ажиллах болно.

3.11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Сэрүүн сэлбэ" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүргүүлж ажилладаг.

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө болон биелэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3.6. Олон нийтэд төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Нийслэлийн байгаль орчны газар, БОАЖЯ	Хорооны ИНХ	Хуралд танилцуулах	БОМТ-ийн 2023 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ний өдрийн дотор	Хорооны төв
	Дүүргийн ЗД, БОХХБайцаагч	Уулзалт			Дүүргийн төв
Төрийн захиргааны төв байгууллага	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	2023 оны БОМТ	12-р сарын 01-ний өдрийн дотор	УБ хот

Бид байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уг төлөвлөгөөний биелэлт болон олон нийтэд тайлагнах, байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээ мэдээллэх, сурталчлах ажлуудаа цаашид илүү сайжруулан ажиллахаар хичээж байна.

3.12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН НЭГТГЭЛ

2023 онд БОМТ-нд нийт 9'315.0 мян.төг зарцуулахаар төлөвлөсөн ба биелэлтийн гүйцэтгэлээр 14'970.0 мян.төгрөг зарцуулсан буюу +100%-ийн гүйцэтгэлтэй ажилласан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3.7. 2023 оны БОМТ-ний нийт зардал, биелэлтийн үзүүлэлтүүд

№	Арга хэмжээ	Төлөвлөгөөнд тусгагдсан зардал, мян.төг	Биелэлтээр гүйцэтгэсэн ажлын зардал, мян.төг	Гүйцэтгэл, %
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2'000.0	2000.0	100%
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2'760.0	2500.0	90.6%
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2'000.0	2'000.0	100%
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Хамааралгүй	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Хамааралгүй	-	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2'000.0	1'750.0	87.5%
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	250.0	550.0	+100%
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	305.0	350.0	+100%
9	Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	Төлөвлөгдөөгүй	4'320.0	+100%
10	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Зардал төлөвлөгдөөгүй	1'500.0	+100%
11	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	Зардал төлөвлөгдөөгүй	Тайлагнасан	+100%
-	Нийт дүн	9'315.0	14'970.0	+100%

ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Сэрүүн сэлбэ” ХХК-ний “Зуун мод-2” барилгын элсний уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг БОАЖ-ын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Элс олборлох үйл ажиллагаа явуулах явцад нөлөөлөлд голчлон өртөгч нь хөрс, ургамал, агаар, газрын ба геологийн тогтоц юм.

Иймд сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх зэрэг ажлуудыг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу хэрэгжүүлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг цаг тухайд нь гүйцэтгэж, үр дүнд нь дүгнэлт хийн ажиллалаа.

2023 онд БОМТ-ний биелэлтийн гүйцэтгэлд нийт 14'970.0 мян.төгрөг зарцуулсан буюу +100%-ийн гүйцэтгэлтэй ажилласан үзүүлэлттэй байна.

Бид цаашдын үйл ажиллагааныхаа явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөө, уг төлөвлөгөөний биелэлтийн ажлуудыг холбогдох хууль, журам, стандарт, аргачлалуудад нийцүүлэн тогтмол сайжруулж ажиллах болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зуун мод-2” элсний ордод 2009 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, УБ-2010 он
2. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зуун мод-2” элсний ордыг ил уурхайн аргаар ашиглах Техник-Эдийн Засгийн Үндэслэлийн тодотгол, УБ-2022 он
3. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зуун мод-2” элсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, УБ-2023 он
4. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зуун мод-2” элсний уурхайн 2023 оны Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, УБ-2023 он
5. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Зуун мод-2” элсний уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, УБ-2023 он
6. Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах” журам
7. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем - www.legalinfo.mn
8. Байгаль орчны мэдээллийн сан - www.eic.mn